



Level : Ecolier

(Монгол улсын ЕБС-ийн 3 – 4-р анги)

3 онооны бодлогууд:


- 1) Өгсөн зураг дээр муур, хулгана хоёрын зам огтлолцохгүй ба муур нь сүү рүү, хулгана бяслаг руу очдог гэнэ. Тэгвэл голд байгаа харлуулсан квадратад дараах зургуудаас аль нь тохирох вэ?



- 2) Хичээл 11:50-д эхэлж 40 минут үргэлжилдэг. Хичээлийн яг дунд үед нэг шувуу ангид орж иржээ. Энэ үед цаг хэд болж байсан бэ?

A) 11:30 B) 12:00 C) 12:10 D) 12:20 E) 12:30


- 3) Индиан омгийн ахлагч Том Баавгай толгойдоо гурван өдтэй, гартаа сүх, сум барьж, гутал өмссөн байна. Түүний хүү Цагаан Барс толгойдоо хоёр өдтэй, гартаа сүхгүй ба сум барьсан. Мөн тэр хөл нүцгэн ба цээжин дээрээ хоёр зураастай гэнэ. Тэгвэл ахлагч Том Баавгай, хүү Цагаан Барс нарыг үзүүлсэн зураг аль нь вэ?



- 4) Зоогийн газарт зутан шөл 4000₮, гуляш 9000₮, мөхөөлдөс 5000₮. Харин зутан шөл + гуляш + мөхөөлдөс гурвууланг нь захиалбал 15000₮. Гурвууланг нь захиалбал хэдэн төгрөг хэмнэх вэ?

A) 3000₮ B) 4000₮ C) 5000₮ D) 6000₮ E) 7000₮

- 5) Гурвалжин дүрс зургаан зоосноос бүрдэнэ. Зарим зоосыг өөрчилж хоёрдахь зурагт үзүүлсэн дүрс бүтээх болов. Тэгвэл хамгийн багадаа хэдэн зоосны байр өөрчлөх вэ?




A) 1 B) 2 C) 3 D) 4 E) 5






6) Дөрвөн найз зайрмаг идэж байв.

- Мишээл Болдоос их,
- Жавхаа Вандангаас их,
- Жавхаа Болдоос бага зайрмаг иджээ.

Хамгийн их идсэнээс бага идсэнээр нь нэрсийг жагсаав. Аль хариулт нь зөв бэ?

- А) Мишээл, Жавхаа, Вандан, Болд В) Вандан, Мишээл, Болд, Жавхаа
С) Мишээл, Болд, Жавхаа, Вандан Д) Жавхаа, Вандан, Мишээл, Болд
Е) Жавхаа, Мишээл, Вандан, Болд

7) Зөвхөн  плита ашиглан өрөөний шалыг хийе гэвэл дараах зурагнуудаас алийг нь хийж болохгүй вэ?

- А)  В)  С)  Д)  Е) 


8) Эрт урьдын цагт 100 хөлтэй луу амьдран суудаг байжээ. Тэр зарим хөлдөө гутал өмсдөг байв. Нэгэн өдөр тэр 16 хос гутал худалдаж аваад өмсчээ. Гэтэл цаана нь 14 хөл гуталгүй байв. Тэгвэл луу өмнө нь хэдэн гутал өмссөн байсан бэ?

- А) 27 В) 40 С) 54 Д) 70 Е) 77

4 онооны бодлогууд:

9) Анужин цаасыг дөрвөн удаа нугалав (зураг харна уу). Тэгвэл цаасыг нугалах үед кенгуру хэдэн удаа давхцах вэ?

- А) 0 В) 1 С) 2 Д) 4 Е) төгсгөлгүй олон



10) Нараа, Сараа хоёр нэгэн өндөр байшинд амьдардаг. Сараагийнх Нараагийнхаас 12 давхрын дээр байдаг гэнэ. Нэг өдөр Нараа Сараагийнд очихоор шатаар явсан ба түүний явсан замын хагас нь 8-р давхар байжээ. Нараа хэдэн давхарт амьдардаг вэ?

- А) 12 В) 14 С) 16 Д) 20 Е) 24

11) Том куб 64 жижиг ижил хэмжээтэй цагаан кубаас бүрдэнэ. Том кубын 5 талсыг нь ногоон өнгөөр будсан бол 3 тал нь ногоон өнгөтэй хэдэн ширхэг куб байх вэ?




- А) 4 В) 8 С) 16 Д) 20 Е) 24



12) Усан онгоц голыг нэг удаа гатлахдаа 10 жижиг эсвэл 6 том машин гаргах даацтай. Лхагва гаригт онгоц голыг таван удаа гатлахдаа 42 машин тээвэрлэжээ. Хэдэн жижиг машин тээвэрлэсэн бэ?

- А) 1 В) 12 С) 20 Д) 22 Е) 30

13) Квадрат дүрс 4 жижиг ижил хэмжээтэй квадратад хуваагддаг. Бүх жижиг квадратуудыг цэнхэр эсвэл ногоон өнгөөр буджээ. Жишээлбэл: зурагт үзүүлсэн дөрвөн дүрсийг нэг будалт гэж тооцно. Тэгвэл хэдэн ялгаатай будалт байх вэ?



- A) 5 B) 6 C) 7 D) 8 E) 9

14) Жаргал аз жаргалын захиа бичээд Уянгаад илгээв. Уянгаа түүнийг хоёр хүн лүү илгээв. Үүнээс цааш захиа авсан хүн бүр хоёр хүнд илгээв. Захиа хоёр дахь дамжуулалтаар $1 + 2 + 4 = 7$ хүнд очсон байна. Тэгвэл дөрөв дэх дамжуулалтын дараа хэдэн хүнд очих вэ?

- A) 15 B) 16 C) 31 D) 33 E) 63

15) Хүүхдүүд элсэн тоглоомын талбайн уртыг хэмжив. Анар 15, Бат 17, Дэлгэр 12, Индра 14 алхам тус тус алхжээ. Хэнийх нь алхаа хамгийн урт вэ?

- A) Анар B) Бат C) Индра D) Дэлгэр E) тодорхойлох боломжгүй

16) Хэрэв хоёр мөрөнд бичигдсэн тоонуудын нийлбэр нь тэнцүү бол *-ын оронд ямар тоо байх вэ?

1	2	3	4	5	6	7	8	9	10	199
11	12	13	14	15	16	17	18	19	20	*

- A) 99 B) 100 C) 209 D) 289 E) 299

5 онооны бодлогууд:

17) $60 \cdot 60 \cdot 24 \cdot 7$ үржвэр нь дараах хариултын алинтай нь тэнцүү вэ?

- A) долоон долоо хоногийн минутын тоо B) жаран өдрийн цагийн тоо
 C) долоон цагийн секундын тоо D) нэг долоо хоногийн секундын тоо
 E) хорин дөрвөн долоо хоногийн минутын тоо

18) 4×4 хүснэгтийн нүд бүрт хөзөр байна (зураг харна уу). Хоёр хөзрийн байр солихыг сэлгэлт гэж нэрлэе. Тэгвэл хүснэгтийн мөр ба багана бүрийн хувьд хөзрийн бүх дүрсүүд байхын тулд хамгийн багадаа хэдэн сэлгэлт хийх вэ?

- A) 1 B) 2 C) 3 D) 4 E) 5

♥	♥	♦	♣
♦	♠	♠	♥
♣	♦	♠	♣
♠	♣	♥	♦

19) Хоёр жилийн өмнө Том ба Жерри хоёрын насны нийлбэр 15 байжээ.

Том одоо 13 настай. Тэгвэл 9 жилийн өмнө Жерри төрөхөд хэдэн жил үлдээд байсан бэ?

- A) 1 B) 4 C) 5 D) 2 E) 3

